



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

50

Тушаалын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8, 15 дугаар зүйлийн 15.4.1, Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.21, 26 дугаар зүйлийн 26.3, Засгийн газрын 2012 оны 123 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын “Сангийн хөрөнгө хуваарилах тухай” 2014 оны 99 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 7 дугаарт “Архидан согтуурахтай тэмцэх тухай бусад орны бодит туршлага, нотолгоонд суурилсан уулзалт зохион байгуулах, Турк болон Тайландын Эрүүл мэндийн сайдыг урих” гэснийг “Архины хортой хэрэглээг бууруулах” үндэсний чуулган зохион байгуулах, Архины хяналтын суурь конвенцийн төсөл боловсруулах” гэж өөрчилсүгэй.
2. Үндэсний чуулган зохион байгуулах ажлыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга, Эрүүл мэндийг дэмжих сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга (Д.Нарангэрэл)-д даалгасугай.
3. Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулсантай холбоотойгоор тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийг дэмжих сангийн зөвлөлийн орлогч дарга (А.Эрдэнэтүяа)-д үүрэг болгосугай.



D:\barimt\tushaal

081689